

МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

**АЗИ, ДАЛАЙН ОРНУУДЫН ЗАЛУУЧУУД
ЭНХ ТАЙВНЫ ТӨЛӨӨ ТЭМЦЭЛД**

«Ази, Далайн орнуудын залуучууд энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны төлөө тэмцэлд» гэсэн уриан дор МХЗЭ-ийн санаачилгаар Дэлхийн Ардчилсан залуучуудын Холбооноос зохион хийлгэсэн олон улсын бага хурал Улаанбаатар хотноо энэ оны 8 дугаар сарын 16--18-ны өдрүүдэд болж өнгөрөв. Тус бүс нутгийн энэ уулзалтад социалист хамтын нөхөрлөлийн орнууд, БНАСАУ, БНКАУ, Ардчилсан Афганистан, Ангол, Энэтхэг, Шри-Ланка, Филиппин, Шинэ Зеланд, Австрали, Япон зэрэг 30 шахам орны залуучууд, оюутны 40 гаруй байгууллага, мөн Дэлхийн Ардчилсан залуучуудын Холбоо (ДАЗХ), Олон улсын оюутны холбоо, Дэлхийн энх тайвны зөвлөл, Олон улсын сурагчдын холбоо, Ази, Африкийн эв санааны нэгдлийн байгууллага, Азийн буддистуудын бага хурлын төлөөлөгчид оролцов.

Бага хурлын төлөөлөгчдөөс илгээлт бичиг гаргаж, Ази, Далайн орнуудын залуучуудын байгууллагын төлөөлөгчдөд энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны тулгамдсан асуудлыг хамтран хэлэлцэх таатай бололцоо олгосон нь чухал арга хэмжээ болсон төдийгүй хүн ам олонтой энэ тивийн залуучууд энх тайван, намжмал байдал, эх дэлхийнхээ ирээдүйн эрх ашгийн үүднээс залуучуудын байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцох явдлыг бэхжүүлэхийн төлөө цуцалтгүй тэмцэх зориг төгс байгаагаа дахин нотолж, 1985 онд Москва хотноо болох дэлхийн залуучууд, оюутны XII их наадамд бэлтгэх хийгээд халуун цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулахын төлөө Ази, Далайн орнуудын залуучуудын байгууллагын хэлхээ холбоог улам өргөжүүлэх, тэдний хүчийг нэгтгэн нягтруулахад чухал алхам боллоо гэж хурлын ач холбогдлыг тодорхойлов.

Тус бага хурлаас «Ази, Далайн орнуудын залуучууд энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны төлөө тэмцэлд» гэсэн төгсгөлийн баримт бичгийг санал нэгтэй батлав.

Орчин үеийн олон улсын харилцаанд Ази тивийн улс гүрнүүд, тэдгээрийн улс төрийн гадаад бодлого чухал нөлөө үзүүлдэг юм. Эдгээр орны энх тайванч гадаад бодлогын нөгөө талд АНУ-аар толгойлуулсан империалист харгис хүчний милитарист адал балмад бодлого түүний хор уршгаар дэлхий дахинд цөмийн дайн гарах аюул занал өсөн нэмэгдэж байгааг онцлон тэмдэглэв.

Дэлхийн газар нутгийн 30 хувь, хүн амын тэн хагасаас илүү хувийг эзэлдэг, 40 гаруй улс орон оршин амьдардаг Ази тивл ЗХУ, социалист бусад орон энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахаар явуулж байгаа тууштай бодлогод тус тивийн залуучууд багагүй хувь нэмэр оруулж ирсэн, одоо ч оруулсаар байна.

Азийн социалист болон социалист чиг баримжаа бүхий орнуудаас дэвшүүлсэн санал санаачилга өнөөгийн олон улсын энэхүү нарийн төвөгтэй нөхцөл байдалд түгшүүртэй голомтуудыг устгах, тус тивийн улсуудын хооронд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэж байна. Энэхүү энх тайванч ариун үйл хэргийн төлөө тэмцэгчдийн тэргүүн эгнээнд азийн социалист орнуудын залуучууд явж байна.

Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд Ази, Далайн орнуудын дэвшилт болон ардчилсан залуучууд, дайны эсрэг хүч чухал үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд тэдгээр хүчний эв нэгдлийг бэхжүүлэх үйл хэрэгт ДАЗХ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын залуучуудын байгууллага чухал хувь нэмэр оруулж байна.

ЗХУКН-ын XXVI их хурлаас Алс Дорнодод харилцан итгэлцэх арга хэмжээний хэлэлцээр боловсруулж байгуулах тухай ЗХУ-ын чухал санаачилгууд, 1983 онд Вьентьянд болсон Энэтхэг-Хятадын хойгийн гурван орны удирдагч нарын зөвлөлгөөнөөс дэвшүүлсэн Зүүн өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдлын бүс болгох, АСЕАН-ы орнуудтай харилцаагаа хэвийн болгох тухай санал, Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц боловсруулж байгуулах БНМАУ-ын санал, БНМАУ-ын Ардын Их Хурлаас, Ази, Номхон далайн бүх улс орны парламентад хандаж гаргасан уриалга, «Улс түмэн энх тайван орших эрхийн» тухай асуудлыг БНМАУ-аас НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXIX чуулганы хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулах зэрэг санал санаачилга нь Азийн байдал нэн түгшүүртэй болж байгаа өнөөгийн нөхцөлд чухал ач холбогдолтой арга хэмжээ болж, Ази, Далайн орнуудын ард түмэн, залуучуудын энх амгалан эв найртай аж төрх үндсэн эрх ашигт бүрэн нийцэж байна. БНМАУ-ын гадаад улс төрийн бодлогын хүч чармайлтын гол зорилт нь улс хоорондын харилцаанд түрэмгийлэх, хүч хэрэглэх явдал гаргуулахгүй байх, тэгснээрээ тус тивийн улс түмэн залуу үеийнхний гүн хүсэл эрмэлзлийг хэрэгжүүлэхэд оршиж байна. Зүүн өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдал, эв найрамдал, хамтын ажиллагааны бүс нутаг болгож, Энэтхэг-Хятадын хойгийн болон АСЕАН-ы орнуудын хооронд түгшүүртэй байдлыг намжааж, яриа хэлэлцээг хангахад чиглэсэн Вьетнам, Лаос, Кампучийн санал зэргийг бага хуралд оролцогчид санал нэгтэй дэмжив.

Ази, Далайн орнуудын дэвшилт ардчилсан, энхийг эрхэмлэгч хүчнийхний хооронд сайн хөршийн нягт харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь орчин үеийн хамгийн хойшлуулшгүй зорилт болж байна гэж төгсгөлийн баримт бичигт онцлон заажээ.

Бага хурал дээр үг хэлсэн олон төлөөлөгчид феодализмаас капитализмыг алгасан социализмд шилжин хөгжсөн БНМАУ-ын түүхэн туршлага нь К. Маркс, Ф. Энгельс нарын боловсруулж, түүхийн шинэ нөхцөлд В. И. Лениний бүтээлчээр хэрэгжүүлсэн нийгмийн хувьсгалын онол, практикт БНМАУ-ын оруулсан том хувь нэмэр болохыг тэмдэглэж дэлхийн харгис хүчнээс бусдын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох санаархлыг таслан зогсооход социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай ойр дотно холбоо тогтоож, интернационализмыг бэхжүүлэх явдал чухал ач холбогдолтой болохыг бид монголын туршлагаас харлаа гэж цохон зааж, монголын ард тү-

мэн ЗСБНХУ-ын ах дүүгийн тусламжийн ачаар социализмыг амжилттай байгуулж түүхэн туршлагыг бодитойгоор үнэлэн дүгнэжээ.

Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгохын төлөө Ази, Номхон далайн бүс нутгийн залуучуудын тэмцэл улам батжиж, Өмнөд Солонгосоос америкийн цэрэг болон цөмийн хэрэгслийг гаргах, Солонгосын энх тайван, ардчилсан үндсэн дээр нэгтгэхийн төлөө Солонгосын ард түмэн, залуучуудын тэмцэлд дэмжлэг үзүүлж байгааг хуралд оролцогсод тэмдэглэв.

Дэлхийн шинэ дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахын төлөө, бүх нийтийн энх тайвныг сахин бэхжүүлэхийн төлөө тэмцэгчдийн эгнээнд монголын залуус явж ирсэн, явсаар ч байна. БНМАУ зэвсэг хураахад тус дөхөм үзүүлэх олон улсын долоо хоногийн ажлыг жил бүр зохион явуулж байхыг санаачилсан нь дайныг эсэргүүцсэн өргөн олны тэмцэлд бүх сайн санаат хүмүүсийн дуу хоолойг нэгтгэхэд ач тусаа үзүүлж байгаа юм. ДАЗХ-ны ерөнхийлөгч Валид Масри монголын залуучуудын энх тайвны төлөө тэмцлийг үнэлэн хэлэхдээ: «Энэхүү уулзалтыг Улаанбаатарт хийж байгаа нь энх тайвны үйл хэргийг сахин хамгаалах, Ази тивийн улс гүрнүүдийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцох явдлыг бэхжүүлэхийн төлөө МАХН-аар удирдуулсан монголын ард түмэн, залуучуудын тавьж байгаа цуцалтгүй хүчин чармайлт, хийж байгаа тэмцлийн бас нэг нотолгоо болж байна»¹ гэж дурджээ.

Ази, Номхон далайн сав газрын энх тайвныг эрхэмлэгч залуучуудын байгууллагуудаас ЗХУ, социалист бусад орны залуучуудын байгууллагуудтай хэлхээ холбоо тогтоох сонирхол улам нэмэгдэж байгаа юм. ЗХУ-ын залуучууд Филиппины залуучуудын «Кабаатан барангай» гэдэг залуучуудын байгууллагын хооронд харилцаа холбоо тогтоосноор энх тайвны төлөө хамтран ажиллах үүд хаалга нээгджээ. Энэ мэт хэлхээ холбоо тогтоож энх тайвныг сахин хамгаалах арга зам эрэлхийлсэн хандлага улам өслөө. Цөмийн дайны аюулыг арилгах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох тэмцэл Ази, Далайн орнуудын бүс нутгийн залуучуудын байгууллагуудын хамтын ажиллагааны нэг чухал хэлбэр болж байна. Ази, Далайн орнуудын бүс нутгийн дийлэнх орны залуучуудын хөдөлгөөний хүрээ, далайц өсөж, дайны эсрэг тэдний хөдөлгөөн, дэлхийн хувьсгалт үйл явцад оролцох нь эрчимжсээр байна.

Ази, Далайн орнуудын бүс нутгийн залуучуудын хийж байгаа тэмцэл, хөдөлгөөн нь нийгэм-эдийн засгийн болон улс төрийн эрхийн төлөө, монопольт капиталын эсрэг, эрх чөлөө, ардчиллын төлөө чиглэж байна.

Империалист харгис хүчнийхэн Ази, Номхон далайн бүс нутгийн залуучуудыг бусад тивийн залуучуудын хувьсгалт үйл амьдралаас хол хөндий байлгах, орчин үеийн олон улсын тулгамдсан асуудалд оролцуулахгүй байхыг хичээх, хагалан бутаргах, үл итгэх, найрамдал, хамтын ажиллагааны үзэл санааг нь эвдэн бусниулах, энх амгалан аж төрж амьдрах ирээдүйн хүсэл эрмэлзлэлийг нь хааж боогдуулах зэрэг гаж буруу үзлийг залуучуудын дунд дэлгэрүүлэх гэж элдвээр оролдож байна.

Энх тайвны төлөө Ази, Далайн орнуудын залуучуудын өрнүүлж байгаа тэмцэл, хөдөлгөөн нь хэлбэр шинж байдлаараа хэдий өөр өөр боловч энх тайвныг бэхжүүлэхийн нэгэн хүсэл эрмэлзлийн уриан дор явагдаж улам тодорхой зорилго чиглэлтэй болж олон түм-

¹ «Үнэн», 1984.VIII.17.

ний талархал дэмжлэгийг олж байна. Ялангуяа энх тайвны төлөө тэмцлийг тухайн улс орны ардчилал, дэвшлийн төлөө тэмцэлтэй холбохын чухлыг Ази, далайн орны залуучууд улам бүр ойлгож байна.

Ази тивд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж, тус тивийн улсуудын хооронд харилцан ойлгох, итгэлцэх, хамтран ажиллах явдлыг бэхжүүлэх зорилгоор дайны эсрэг, энх тайвны төлөө Ази тивийн залуучуудын гаргаж байгаа хүч чармайлтыг нэгтгэх явдал юу юунаас илүү чухлаар шаардагдаж байна.

Д. Самбалхүндэв